



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2013 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Гадна сурталчилгааны байгууламжид  
тавигдах тусгай шаардлага батлах тухай

Монгол Улсын Зар сурталчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахад дагаж мөрдөх журам”-ын 5 дугаар бүлгийн 5.4.2; 5.4.3 дахь заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар бүлгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахад тавигдах тусгай шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Гадна зар сурталчилгааны зөвлөлийн гишүүнээс Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын Дахин төлөвлөлтийн хэлтсийн дарга М.Нямбаярыг чөлөөлж, Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын Архитектур, дизайны хэлтсийн дарга Д.Энхцогтыг томилсугай.


3. Тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихыг Дүүргүүдийн Засаг дарга нар, Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Т.Батбаяр/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА

Б.БАДРАЛ



1110300682



## Гадна зар сурталчилгааны байгууламжид тавигдах шаардлага

### 1. Ерөнхий шаардлага

- 1.1 “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг мөрдөх, түүнтэй уялдуулан зохион байгуулах
- 1.2 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 3/32 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахад дагаж мөрдөх журам”-д тавигдах шаардлагад нийцүүлэн гадна зар сурталчилгаа, мэдээллийн байгууламжийг байрлуулах ба дээрх тогтоолын 2 дугаар хавсралтад заасан гудамж, талбайд байрлуулахгүй байх
- 1.3 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зүгээс ирүүлсэн Гадна зар сурталчилгааны талаарх шинэ загвар, тоо хэмжээ, байршлын саналыг дүүрэг бүрт нэгтгэн, дүүргийн Ажлын хэсгээс Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай нөхцөлд Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас Ажлын зургийн даалгавар боловсруулан дүүргүүдэд хүргүүлнэ.
- 1.4 Ажлын зургийн даалгаврын дагуу тухайн гудамжны тохижилтын онцлогтой уялдуулан Гадна зар сурталчилгааны төлөвлөлтийн зургийг боловсруулж Зөвлөлийн хуралд оруулан батлуулна.
- 1.5 Нэг орон зайд нэгэн жигд загвар, хэмжээтэй байх зарчмыг баримтлах

### 2. Тулгуурт сурталчилгааны байгууламж нь дараах шаардлагыг хангасан байна.

- 2.1. Тулгуурт байгууламж нь газарт хөдөлгөөнгүй суурилагдсан биллбоард самбар, гэрэлт хайрцаг /light box/ хэлбэрүүдтэй байх ба авто замтай паралель болон перпендикуляр байрлалтай байж болно.
- 2.2. Тулгуурт сурталчилгааны байгууламжийг замын байгууламжаас 1,5 метр, уулзвараас 20 метрээс багагүй зайд байрлуулна.
- 2.3. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 3/32 тоот тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахад дагаж мөрдөх журам”-д заасан хориглосон гудамжид байрлуулахгүй.
- 2.4. Замын байгууламжаас 1,5 метр зайд тулгуурт сурталчилгааны байгууламжийн хязгаарын шугам байх ба хязгаарын шугамаас гадагш 6 метрээс дотогш зайд барилга, объект байрласан бол тухайн байрлалд тулгуурт байгууламж байрлуулахгүй байх;
- 2.5. Хязгаарын шугамнаас барилгажих талбай хүртэлх зайн 1/3 хэсэгт багтаан сурталчилгааны байгууламжийг байрлуулна.

- 2.6. Тулгуурт байгууламжийг байрлуулахдаа гудамж, замын өргөн, урт зэргээс шалтгаалан авто замын зэрэглэлийн дагуу хэм хэмжээг баримтална.
- 2.7. Авто замтай перпендикуляр байх нөхцөлд тулгуурт байгууламж нь гэрэлт хайрцаг /Ligth box/ хэлбэртэй байх ба нийт овор хэмжээ, өөр хоорондын зай
  - 1-р зэргийн гол гудамж зам дагуу 4,0 x 1,0 /өндөр, өргөн/ метрээс ихгүй, өөр хоорондоо 250 метрээс багагүй
  - 2-р зэргийн гол гудамж зам дагуу 5.5 x1,0 /өндөр, өргөн/ метрээс ихгүй, өөр хоорондоо 250 метрээс багагүй
  - 1-р зэргийн туслах гудамж, зам дагуу 5,5x1,0 /өндөр, өргөн/ метрээс ихгүй, өөр хоорондоо 250 метрээс багагүй
  - 2-р зэргийн туслах гудамж, зам дагуу 3.5x1,0 метрээс ихгүй, өөр хоорондоо 250 метрээс багагүй
- 2.7 Хот хоорондын авто зам болон гадна зар сурталчилгааны төлбөрийн хоёрдугаар зэрэглэлд байрлах гудамжид байрлах тулгуурт байгууламж нь биллбоард хэлбэртэй байж болох ба тулгуур хэсэг 7 метр, өөр хоорондоо 300 метрээс багагүй зайд байрлана. /3x6 м, 4\*9 м, 5\*12м/
- 2.8 Авто замтай паралель байрлах нөхцөлд тулгуурт байгууламжийн нийт овор хэмжээ, өөр хоорондын зай
  - 16 метрээс уртгүй,
  - 5,5 метрээс өндөргүй
  - Өөр хоорондоо 300 метрээс багагүй зайд байрлах; /Хоорондын зай нь байгууламжийн захын хэсгээс хажуугийн байгууламжийн наад захын цэг хүртэл/
- 2.9 Дотор эсвэл гадна гэрэлтүүлэгтэй байх;
- 2.10 Газраас тулах хэсгүүд /тулгуур/ нь саарал өнгөөр будагдсан байх;
- 2.11 Замын хөдөлгөөний хяналтын камерын үзэгдэх орчинг хаахгүй байх;
- 2.12 Тулгуурт байгууламжийн тулах хэсэгт эзэмшигч байгууллагын нэр, хаяг, утасны дугаар бүхий мэдээллийг байрлуулсан байх
- 2.13 Явган зорчигчийн замыг хаахгүй байх, аюулгүй байдлыг хангасан байх

### 3. Дээврийн байгууламжид тавигдах шаардлага

- 3.1. Дээврийн байгууламж нь лед дэлгэц, неон гэрлэн чимэглэл болон бусад хэлбэрүүдтэй байж болно
- 3.2. Барилга байгууламжийн насжилт, даац, өндөр, өргөн хийц, загвар зэргээс шалтгаалан дээврийн байгууламж байрлуулж болох эсэхэд Дүүргийн ажлын хэсэг /мэргэжлийн хяналтын байцаагч/ дүгнэлт гаргасан байх;
- 3.3. Барилга байгууламжийн өмчлөгч, эзэмшигчээс албан ёсны зөвшөөрөл авч гэрээ байгуулсан байна
- 3.4. Журамд зааснаас гадна төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга, объектын хананд байрлуулахыг хориглоно.
- 3.5. 5 хүртэл давхар барилгын дээвэрт байрлуулахаар бол сурталчилгааны байгууламж нь барилгын өндрийн 20 хувиас хэтрэхгүй байна.

#### 4. Түр байгууламжид тавигдах шаардлага

- 4.1 Зам болон замын байгууламж дээр байрлуулахыг хориглоно.
- 4.2 Шууд тээвэрлэх боломжтой байх
- 4.3 Зөөврийн лед дэлгэц, хөндий байгууламж зэрэг хэлбэрүүдтэй байж болно.
- 4.4 Түр байгууламжийг 1 сар хүртэл хугацаатай байрлуулах ба сунгах тохиолдолд дүүргийн Засаг даргын тамгын газарт хандана.
- 4.5 Явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулахгүй байх

#### 5. Барилга байгууламжийн ханан дахь байгууламжид тавигдах шаардлага

- 5.1 Барилга байгууламжийн насжилт, даац, өндөр, өргөн хийц, загвар зэргээс шалтгаалан ханын байгууламж байрлуулж болох эсэхэд Дүүргийн ажлын хэсэг /мэргэжлийн хяналтын байцаагч/ дүгнэлт гаргасан байх
- 5.2 Барилга байгууламжийн өмчлөгч, эзэмшигчээс албан ёсны зөвшөөрөл авч гэрээ байгуулсан байна
- 5.3 Барилгын хананд лед дэлгэц болон хулдаасан хэвлэл гэх мэт хэлбэрээр байж болно.
- 5.4 Ханын байгууламжийн хэмжээг тухайн барилгын өндөр, өргөн хийц, загвар зэргээс шалтгаалан зохистой хэмжээг Дүүргийн Ажлын хэсэгтэй зөвшилцөн тодорхойлно.
- 5.5 Тухайн барилгын объектын хананы цэвэр талбайн 2/3 хүртэл хэсэгт байрлуулж болно. /Цэвэр талбай нь барилгын гадна фасадны цонхгүй хэсгийн талбай/
- 5.6 Цонхгүй хананд сурталчилгаа байрлуулах бол хананы талбайг бүрэн хамруулж болно.
- 5.7 Барилгын хаяг, дугаарыг халхлахгүй байх

#### 6. Гүүрэн байгууламжид тавигдах шаардлага:

- 6.1 “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахад дагаж мөрдөх журам”-ын 4.5.4, 4.5.5, 4.5.6 дахь заалтын шаардлагыг хангасан байх;
- 6.2 Уг байгууламжийн хэлбэр дүрс болон түүн дээрх сурталчилгаа нь авто замын хөдөлгөөн зохицуулах техник, хэрэгслүүдтэй ижил буюу төстэй, замын хөдөлгөөний цагийн байдлыг үнэлэхэд саад болохгүй байх;
- 6.3 Авто замын хөдөлгөөний зохицуулах техник, хэрэгслүүдийн үзэгдэх орчинг халхлахгүй байх;
- 6.4 Авто замын дагуугийн налуу нь дөрвөн хувиас дээш бол түүний ойролцоо байрлуулахгүй.
- 6.5 Замын байгууламжаас 1,5 метрээс ойр зайнд түүний тулгуурыг байрлуулахыг хориглоно.
- 6.6 Байршлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

7. Нийтийн тээврийн зогсоол дахь байгууламжид тавигдах шаардлага

- 7.1 Нийтийн тээврийн зогсоолын салшгүй бүрдэл хэсэг байна.
- 7.2 Нийтийн тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулахгүй байх.

8 Онцгой нөхцөл:

Гадна сурталчилгааны байгууламжийг байрлуулах талаар дээрх шаардлагад тусгагдаагүй боловч сурталчилгааны байгууламжийг байрлуулах боломжтой хэмээн дүүргийн “Ажлын хэсэг”-ээс үзсэн нөхцөлд Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.